# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 07 сарын 22 өдөр  Дугаар 291  Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.2.3, 6.4.3, 6.4.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрчим хүчний яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжгүй болох нь тогтоогдсон нийт 7,974,350.00 (долоон сая есөн зуун далан дөрвөн мянга гурван зуун тавин) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайханд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  А.АРИУНБОЛД

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Ц.ТҮВШИНЗАЯА

0000539

Төрийн өмчийн бодлого, зохицуула
2019 оны 07 дугаар сарын 2
291 ...дугаар тогтооль

**Эрчим хүчний яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах хөрөнгийн жагсаалт**

| Хөрөнгийн нэр | Ашиглалтад орсон огноо | Хэмжих нэгж | Тоо | Нэг бүрийн үнэ /төгрөг/ | Балансын үнэ /төгрөг/ | Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/ |
|---|---|---|---|---|---|---|
| хурууны хээгээр бүртгэгч өмж | 2012/01/01 | ш | 1 | 1,155,000.00 | 1,155,000.00 | 1,155,000.00 |
| Устгагч, | 2012/01/01 | ш | 1 | 219,000.00 | 219,000.00 | 219,000.00 |
| он аппарат | 2012/01/01 | ш | 1 | 22,500.00 | 22,500.00 | 22,500.00 |
| ь | 2005/09/30 | ш | 2 | 1,626,750.00 | 3,253,500.00 | 3,253,500.00 |
| ер | 2008/06/03 | ш | 1 | 1,700,000.00 | 1,700,000.00 | 1,700,000.00 |
| ерын дэлгэц суурийн хамт | 2009/03/25 | ш | 1 | 1,444,350.00 | 1,444,350.00 | 1,444,350.00 |
| чигч Voice recorder | 2009/05/15 | ш | 1 | 180,000.00 | 180,000.00 | 180,000.00 |
| **Нийт дүн** | | | **8** | **6,347,600.00 (зургаан сая гурван зуун дөчин долоон мянга зургаан зуун)** | **7,974,350.00 (долоон сая есөн зуун далан дөрвөн мянга гурван зуун тавин)** | **7,974,350.00 (долоон сая есөн зуун далан дөрвөн мянга гурван зуун тавин)** |